



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,  
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.24 № 3/371

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эмгэг судлалын үндэсний төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланда аудит хийв.

### Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Эмгэг судлалын үндэсний төвийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Эмгэг судлалын үндэсний төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.Ж

Ц.НАРАНЧИМЭГ



**YAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2016  
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:**

САГ-ын дарга  
Тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас:261663  
Цахимхаяг:  
[naranchumeg@audit.gov.mn](mailto:naranchumeg@audit.gov.mn)

**Аудитынтайлан**

Хавсралт 1: Агуулга  
Хавсралт 2: Аудитынгэрчилгээ  
Хавсралт3: Менежментийн захидал  
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн  
тайлан  
Хавсралт 5: Аудит хийсэн төсвийн  
гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер: Я.Самбууням  
Утас: Цахимхаяг:audit.gov.mn

Аудитор:С.Галсанчоймбол  
Утас: 89210855  
Цахимхаяг: TSTBaudit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын  
газар  
Байршил: Чингэлтэй дүүрэг 3Г-н  
4-р байр  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

**2016 оны 01 дүгээр сарын 28**

## **АГУУЛГА**

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагынзорилго, ўйлажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитынаргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтынсорилболоннарийвчилсангорим, түүний үр дүн
5. Материаллаг байдлын түвшин
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэнголзөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус запруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланда хийсэнаудитаарилэрсэнзөрчлийннэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

## **1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Эмгэг судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/302/ СТА-ТШЗ/ аудит хийлгээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Эмгэг судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайланг УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Эмгэг судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 23-аас 2017 оны 02 дугаар сарын 20-ныг хүртэл хийхээр төлөвлөн “Цэгцтөв бодг аудит” ХХК-ийн 3 дугаар багийн аудитор С. Галсанчоймбол аудиторын туслах ажилтан Б. Марал нар хэрэгжүүлэв./ТАБ-СТА-А-9/

Эмгэг судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 01 дугаар сарын 23-нд “Цэгцтөв бодг аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Цэгцтөв бодг аудит” ХХК аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 23-аас 2017 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд Эмгэг судлалын үндэсний төвийн удирдлагад гардуулна.

## **2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Эмгэг судлалын үндэсний төвийн төсвийн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай хууль” /нэмэлт өөрчлөлт орсон/, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Төрийн албаны тухай хууль” /нэмэлт өөрчлөлт орсон/, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил

үйлчилгээ худалдан авах тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Төрийн аудитын тухай хууль”, “Нийгмийн даатгалын тухай хууль”, “ХХОАТ-н тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль”, “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль”, “Санхүүгийн түрээс лизингийн тухай хууль”, “Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль”, “Шилэн дансны тухай хууль”-ууд болон эдгээр хуулиудтай нийцүүлэн гаргасан Засгийн газрын тогтоол, Эрүүл мэнд, спортын яамны сайдын тушаал, Сангийн сайдын тушаал, бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

### **3. Байгууллагынзорилго, үйлажиллагаа:**

Зорилго:

Эмгэг судлалын үндэсний төвийн зорилт нь Эмгэг судлалын тусламж үйлчилгээг үзүүлж, оношлогоо эмчилгээний магадлалыг дээшлүүлэх, эмгэг судлалын шинжилгээнд дэвшилтэт аргыг нэвтрүүлэн, нотолгоо түшсэн оношлогооны чанарыг сайжруулж, эмнэл-зүйн эмч нарын мэдлэгмэргэжлийг дээшлүүлэхэд оршино.

Чиг үүрэг: ЭСҮТөв нь:

-Амьд ахуйн эд эсийн шинжилгээ /мэс заслаар тайрч авсан эд эрхтэн, онош тогтоох зорилгоор авсан дурангийн болон амбулатороор хийгдэж буй жижиг мэс ажилбар/-ын материалыг эд эсийн түвшинд ялган оношлон дүгнэлт өгөх

- Эмнэлэгт эмчлэгдэж байгаад нас барсан тохиолдолд эмгэг судлалын задлан шинжилгээ хийж, эмчилгээ оношлогоо тохироог шалган баталж клиникийн эмч нарын мэдлэг мэргэжил, хариуцлагыг дээшлүүлэх

-Онош зөрсөн болон ховор тохиолдолд эмгэг судлал-эмнэл зүйн эмч нарын хамтарсан зөвлөгөөнийг хийж эмчилгээ үйлчилгээний доголдол, дутагдалыг шүүн хэлэлцэх

-Аймаг орон нутгийн мэргэжил нэгт эмгэг судлалын эмч нарт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх үүрэгтэй.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангах ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагч байна”. 16 дугаар зүйлийн 16.4.18-д “Төсвийн бусад байгууллагын дарга тухайн байгууллагын төсвийн захирагч байна” гэж заасны дагуу Эмгэг судлалын үндэсний төвийн дарга төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. ЭСҮТөвийн 2016 оны төсвийг ЭМС-ын яамнаас баталж, төв төрийн сангаас харилцах дансаар дамжуулан олгож байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой “Иргэний хууль”, “Төсвийн тухай хууль”,

“Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Төрийн албаны тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Төрийн аудитын тухай хууль”, “Нийгмийн даатгалын тухай хууль”, “ХХОАТ-н тухай хууль”, “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль”, “Санхүүгийн түрээс лизингийн тухай хууль”, “Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль”, “Шилэн дансны тухай хууль”-үүд болон эдгээр хуулиудтай нийцүүлэн гаргасан Засгийн газрын тогтоол, Эрүүл Мэндийн сайдын тушаал, Сангийн сайдын тушаал, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын тушаал бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Эмгэг судлалын төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

#### **4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний ур дун:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Эмгэг судлалын үндэсний төвийн 2016оны санхүүгийн тайлан дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.  
/ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансадад түүвэрчилсэн байдлаараудитын нарийвчилсан горим, сорил 45-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Эмгэг судлалын үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг НББОУС, УСНББОУС, нягтлан бодох бүртгэлийн програм хангамжинд нийцүүлэн боловсруулж мөрдөж ажилласан байна.

Эмгэг судлалын үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Эмгэг судлалын үндэсний төвийн санхүүгийнүйлажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн “E-Account system” программаар боловсруулсан санхүүгийн тайлан бэлтгэхаргачлалын дагуу санхүүгийн тайланг бэлтгэсэн байна. Программ нь зарим тохиолдолд дүнг татахгүй байх, эдийн засгийн ангиллыг буруу бүртгэх, цалингийн программ нь сард 2 удаа

цалинг суутгал хийн боддог нь алдаа гарах магадлал өндөр байхг.м алдаанууд байлаа.

### **5. Материаллаг байдлын түвшин**

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардлын 2 хувиар тогтоож, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 28,857.1мянган төгрөг гэж тооцов.

Учир нь: Улсын төсвөөс санхүүждэг өөрийн орлогоор материаллаг байдлын суурийг тодорхойлоход хангалттай бус учир нийт зардлыг материаллаг байдлын суурь болгон авч материаллаг байдлын түвшинг хоёр хувиар тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

### **6. Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эмгэг судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны санхүүгийн тайлан, нягтлан бodoх бүртгэл, журналыг үйл ажиллагааны санхүүгийн баримттай тулгах байдлаар аудит хийх явцад өмнөх аудитаар илэрч байсан зөрчил давтагдахгүй байгаа зэргээс үзэхэд санхүүгийн үйл ажиллагаа сайжирсан гэж дүгнэж байна.

### **7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

2016 оны батлагдсан төсвийгсар, улирлын хуваарийн дагуу төв төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлж, төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан, төсвийн санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу зардлын зүйл ангиар зарцуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажилласан байна.

ЭСҮТ-ийн төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс 1,149,253.9 мянган төгрөгийн санхүүжилт, үйл ажиллагааны орлогоор 98,667.3 мянган төгрөгийт 1,247,921.2мянган төгрөгийн орлого болон мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 7.0 мянган төгрөгөөрурсгал зардал1,247,928.2мянган төгрөгийг санхүүжүүлсэн байна.

### **8. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Энэхүү хуулийн зорилт нь улс орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор, төсвийн удирдлагын хэрэгжүүлж байгаа шийдвэр үйл ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино гэж заасан байна.

Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 394-р тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох” тухай журам батлагдсаны дагуу Эмгэг судлалын үндэсний төв нь байгууллагын вэб сайтад шилэн дансаа нээж 2016 оны төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын мэдээлэл, бусад хөрөнгө зарцуулсан шийдвэрүүдийг шивж оруулсан байна. Бусад мэдээлэлд орон тооны мэдээлэл, хөрөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл зэргийг шивж оруулсан байна. Цалингаас бусад 5 сая төгрөгнөөс дээш дүнтэй гүйлгээ хийсэн мэдээлэл байхгүй байна.

#### **9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний ур дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 дансанд эрсдлийг тогтоож, батlamж мэдэгдлүүдийн хүрээнд хяналтын болон нарийвчилсан горим, сорил 21-ийг гүйцэтгэв.

Аудитын гүйцэтгэлээр төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж авч үзсэн эрсдлүүдээс цалингийн өглөг, зардлын данстай холбоотой ажилчдын цалин хөлс, амралтын олговорыг журмын дагуу тооцоогүй зөрчлүүд ньсанхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, батlamж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:**

Эмгэг судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайландаа нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, цалин хөлс, зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлого, зардал, хөрөнгийн 65 хувийг эзэлж байна.

#### **11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаархөндөгдсөнголасуудлуудыгдараахзаалтадхураангуйлантэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдааилэрсэн байна. Үүнд:

- Зарим ажилтны цалинг алдаатай тооцож илүү 752.3 мянган төгрөг, дутуу 414.5 мянган төгрөг олгосон нь үнэн зөв байдал батlamж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн:**“Нягтлан бодох бүртгэлийн тухай” 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах мөн хуулийн 15 дугаар зүйлийн дагуу алдааг залруулах зөвлөмж өгөв.

2. ХХОАТ-ын тайланд 548.4 мянган төгрөг дутуу тайлагнасанхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүйбайна.

**Шийдвэрлэсэн:** “Няглан бодох бүртгэлийн тухай” хуулийн 20.2.7-д “Аж ахуйн нэгж байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

3. Батлагдсан эмгэг судлаач эмчийн орон тоог дутуу ажиллуулж, цалинг нь орлон ажилласан эмчид нэмэгдэл хөлс хэлбэрээр олгосон байна. Нийт нэмэгдэл хөлс 354.0 сая төгрөг нь цалингийн сангийнхаа 44 хувийг эзэлж байгаа ч жилийн батлагдсан цалингийн сандаа багтаж байна.

**Шийдвэрлэсэн:** “Төсвийн тухай” хуулийн 6.4-д Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсний дагуу төсвийг боловсруулж байхыг зөвлөмж болгов.

4. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 157.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө үлдэх өртөггүй болсон нь санхүүгийн тайлангийн эрх үүрэг батламж мэдэгдэлд нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн:** УСНББОУС-17-д зааснаар элэгдлээрээнхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө цаашид ашиглагдахаар байвал дахин үнэлгээ хийх, ашиглагдахгүй бол Төрийн өмчийн хороонд асуудлыг оруулан шийдвэрлүүлэхээр зөвлөмж өглөө.

5. “Хөлсөөр ажиллах гэрээ”-ээр ажилласан ажилтанд нэмэгдэл хөлс урамшуулалт олгосон нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Шийдвэрлэсэн:** “Иргэний” хуулийн 359.1-д “ хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллагч нь тохиролцсон ажил, үйлчилгээг гүйцэтгэх, ажиллуулагч нь хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ” гэснийг хэрэгжүүлж гэрээнд заасан хөлсийг гэрээт ажилтанд олгож байхаар зөвлөмж өгөв.

6. Ажиллагсдын амралтын олговорыг тооцоход дундаж цалинг зааврын дагуу тооцоогүйн улмаас 7,216.6сая төгрөгийн цалинг илүү олгосон нь санхүүгийн тайлангийн үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн:** “Няглан бодох бүртгэлийн тухай” хуулийн 20.2.7-д “Аж ахуйн нэгж байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэсэн заалт зөрсөнд зөвлөмж өгөх.

## **12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар**

Аудитын явцад материаллаг бус хэмжээний санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг зөрчсөн алдаа илрээгүй болно.

**13.Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Байгууллагын хамтын гэрээ,хөдөлмөрийн дотоод журамд Хөдөлмөрийн хууль, Төрийн албаны хууль гэх мэт хуулиудаас төсөв хөрөнгийг зарцуулж болох бүх заалтуудыг давхардуулан оруулсан, тэдгээр журмаа үндэслэн цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг олгодог нь төвийг үрэлгэн зарцуулах боломжийг бүрдүүлж байна.

**14.Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Эмгэг судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

**15.Санхүүгийн тайланд хийсэнаудитаарилэрсэнзөрчлийннэгтгэл:**

Эмгэг судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайланд материаллаг бус хэмжээний нийт 8,944.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтахгүй байхыг зөвлөв.

**16.Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Эмгэг судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

**17.Зөрчилгүй санал дүгнэлт**

Эмгэг судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны 2016оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажилгүйлгээнүүдхолбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударгаилэрхийлэгдсэн байна.

Аудитдагсан санхүүгийн тайлан 10 хуудас, хавсралтууд 4 хуудсыг тус тус хавсаргав.



# ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

САГ-ын дарга  
Тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663  
Цахимхаяг:  
naranchumeg@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням  
Утас: Цахимхаяг: audit.gov.mn

Аудитор: С.Галсанчоймбол  
Утас: 89210855  
Цахимхаяг: TSTBaudit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын  
газар  
Байршил: Чингэлтэй дүүрэг 3Г-н  
4-р байр  
Цахим хуудас: www.audit.mn

## Менежментийн захидал

### Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1	1
Үндсэн хөрөнгө .....	1
Асуудал 2	2
Төсөв төлөвлөлт.....	2
Асуудал 3	3
Нягтлан бодох бүртгэлийн хэрэгжилт.....	3
Асуудал 4	4
Гэрээт ажилтны хөлс төлөлтийн талаар.....	4

## **МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Эмгэг судлалын үндэсний төв”-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгдсэн ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнан, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Эмгэг судлалын үндэсний төвийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Асуудал 1. Үндсэн хөрөнгийн талаар:****Тэргүүлэх ач холбогдол №1****Аудитын ажиглалт**

1.1 Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 157.2сая төгрөгийн үндсэн хөрөнгө үлдэх өртөггүй болсон байна.

**Аудитын зөвлөмж**

УСНББОУС-17-дзааснаар элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө цаашид ашиглагдахаар байвал дахин үнэлгээ хийх, ашиглагдахгүй бол Төрийн өмчийн хороонд асуудал оруулан шийдвэрлүүлэх.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ,ҮЗ/

**Төсвийн захирагчийн хариу**

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана гэсэн хариу ирүүлсэн.

**Асуудал2: Төсөв төлөвлөлтийн талаар:****Тэргүүлэх ач холбогдол №2****Аудитын ажиглалт**

2.1 Төлөвлөлтөд зардал хэмнэх, бодитой байх зарчмыг баримтлан үндэслэлтэй боловсруулаагүй,эмгэг судлаач эмч нарын олдоц ховор байдгаасорон тоо дутуу ажиллажхэмнэгдсэн цалинг нэмэгдэл хөлс хэлбэрээр олгосон байна. Нийт нэмэгдэл хөлс 354.0 сая төгрөг байна.

**Аудитын зөвлөмж**

“Төсвийн тухай” хуулийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ /

**Төсвийн захирагчийн хариу**

“Төсвийн тухай хуулийн зохих заалтуудыг хэрэгжүүлэн зөвлөмжийн дагуу ажиллана” гэсэн хариуг ирүүлсэн.

**Асуудал3:Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн талаар:****Тэргүүлэх ач холбогдол №3**

### **Аудитын ажиглалт**

3.1 Зарим ажилтны цалинг алдаатай тооцож илүү 752.3 мянган төгрөг, дутуу 414.5 мянган төгрөг олгосон нь үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ /

### **Аудитын ажиглалт**

3.2ХХОАТ-ын тайланд 548.4 мянган төгрөг дутуу тайлагнасан ньсанхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

### **Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ /

### **Аудитын ажиглалт**

3.3Ажилтнуудын амралтын цалинг бодохдоо дундаж цалин хөлс тодорхойлох журмыг зөрчиж унаа, хоолны хөнгөлөлтийг амралтын цалингийн дундаж цалин тодорхойлох түүвэрт оруулан тооцож 7,217.6 мянган төгрөгийг илүү олгосон байна.

### **Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ /

### **Аудитын зөвлөмж**

“Нягтлан бодох бүртгэлийн тухай” 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах мөн хуулийн 15 дугаар зүйлийн дагуу алдааг залруулах.

### **Төсвийн захирагчийн хариу**

Зохих журмын дагуу 2017 оны 1-р улиралд залруулна гэсэн хариуг ирүүлсэн.

### **Аудитын зөвлөмж**

“Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 20.2.7-д “Аж ахуйн нэгж байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

### **Төсвийн захирагчийн хариу**

Зөвлөмжийг хэрэгжүүлэн зохих залруулгыг хийнэ гэсэн хариуг ирүүлсэн.

### **Аудитын зөвлөмж**

“ХНХ-ын сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар батлагдсан журмын 4-т “Ажилтанд олгож байгаа бүх төрлийн /жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвараа алдсаны, ажилгүйдлийн, тэтгэвэрт гарах үеийн ажилтанд олгох гэх мэт/ тэтгэмжүүд, нөхөн олговор, хөнгөлөлтийн орлого, /унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлтийн/ыг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй” гэсэн заалтыг мөрдөх

### **Төсвийн захирагчийн хариу**

Зөвлөмжийг хэрэгжүүлэн журам мөрдөж Ажиллана гэсэн хариуг ирүүлсэн.

## **Аудитын ажиглалт**

4.1 Хөлсөөр ажиллах гэрээт ажилтанд нэмэгдэл хөлс урамшуулал олгосон нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангагүй байна.

## **Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ /

## **Аудитын зөвлөмж**

“Иргэний” хуулийн 359.1-д “ хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллагч нь тохиролцсон ажил, үйлчилгээг гүйцэтгэх, ажиллуулагч нь хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ” гэснийг хэрэгжүүлж гэрээнд заасан хөлсийг гэрээт ажилтанд олгож байх.

## **Төсвийн захираагчийн хариу**

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэн зохих арга хэмжээ авч ажиллана гэсэн хариуг ирүүлсэн.

**Аудиторын дүгнэлтийн хавсралт 1**

**АУДИТ ХИЙСЭН ҮЛДЭГДЭЛ БАЛАНС**

СТ-1

**"Эмгэг судлалын үндэсний төв"**

(Байгууллагын нэр)

2017 он

(төгрөгөөр)

Балансын зүйл	Үлдэгдэл	
	01 дүгээр сарын 01	12 дугаар сарын 31

**A.Хөрөнгө**

**1. Эргэлтийн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгө	9,532.04	2,532.04
харилцах	-	-
Дансны авлага	-	-
Татвар НДШ-ийн авлага	-	-
Бусад авлага	-	-
Бэлэн бүтээгдэхүүн	-	-
Бичиг хэргийн материал	-	-
ТЭМ	2,500.00	168,262.00
Хангамжийн материал	1,886,610.75	617,836.76
Богино хугацаат хөрөнгө оруулалт	-	-
Дуусаагүй үйлдвэрлэл	-	-
Зээлийн эрсдэлийн сан	-	-
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
<b>Эргэлтийн хөрөнгийн дун</b>	<b>1,898,642.79</b>	<b>788,630.80</b>

**2. Эргэлтийн бус хөрөнгө**

**Биет хөрөнгө**

Барилга байгууламж	190,182,868.33	186,842,235.23
Авто- тээврийн хэрэгсэл	15,468,260.69	9,600,427.37
Машин тоног төхөөрөмж	764,747,442.03	711,097,509.58
Тавилга, аж ахуйн эд хогшил	21,303,673.00	25,680,421.43
Бусад үндсэн хөрөнгө	-	-
Хуримтлагдсан элэгдэл	-	-
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	-	-
Хуримтлагдсан элэгдэл	-	-
Дуусаагүй барилга	-	-
<b>Биет хөрөнгийн дун</b>	<b>991,702,244.05</b>	<b>933,220,593.61</b>

**Биет бус хөрөнгө**

Патент	755,777.77	515,777.76
Зохиогчийн эрх	-	-
Бусад (программ хангамж)	-	-
<b>Биет бус хөрөнгийн дун</b>	<b>755,777.77</b>	<b>515,777.76</b>

Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө

<b>Эргэлтийн бус хөрөнгийн дун</b>	<b>992,458,021.82</b>	<b>933,736,371.37</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДУН</b>	<b>994,356,664.61</b>	<b>934,525,002.17</b>

**Б.Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч****1. Өр төлбөр****Богино хугацаат өр төлбөр**

Дансны өглөг	-	-
Цалингийн өглөг	-	-
Татварын өглөг	-	-
ХХОАТ-ын өглөг	-	-
НӨАТ-ын өглөг	-	-
ЭМНДШ-ийн өглөг	-	-
Банкны богино хугацаат зээл	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	-	-
УОО	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
Түрээсийн өглөг/ бусад татварын өглөг/	-	-
<b><u>Богино хугацаат өр төлбөрийн дүн</u></b>	<b><u>-</u></b>	<b><u>-</u></b>

**Урт хугацаат өр төлбөр**

Урт хугацаат бондын өглөг	-	-
Урт хугацаат зээлийн өглөг	-	-
Бусад урт хугацаат өглөг	-	-
Урт хугацаат өглөгийн хасагдуулга	-	-
<b><u>Урт хугацаат өр төлбөрийн дүн</u></b>	<b><u>-</u></b>	<b><u>-</u></b>
<b><u>Нийт өр төлбөрийн дүн</u></b>	<b><u>-</u></b>	<b><u>-</u></b>

**2. Эзний өмч**

Засгийн газрын хувь оролцоо	368,401,756.70	368,401,756.70
нэмж төлөгдсөн капитал		
<b><u>Цэвэр өмчийн дүн</u></b>	<b><u>368,401,756.70</u></b>	<b><u>368,401,756.70</u></b>
Дахин үнэлгээний өөрчлөлт	-	-
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг /алдагдал/		
Тайлант хугацааны ашиг /алдагдал	724,886,897.91	(59,831,662.44)
Өмнөх үеийн	(98,931,990.00)	625,954,907.91
<b><u>Эзэмшигчдийн өмчийн дүн</u></b>	<b><u>368,401,756.70</u></b>	<b><u>368,401,756.70</u></b>
<b><u>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН</u></b>	<b><u>994,356,664.61</u></b>	<b><u>934,525,002.17</u></b>

**Аудиторын дүгнэлтийн хавсралт 2**

**АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

**СТ-2**

**"Эмгэг судлалын үндэсний төв"**

(Байгууллагын нэр)

2017 он

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
<b>1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	<b>2,147,719,475.39</b>	<b>1,383,025,762.00</b>
Улсын төсвөөс	1,063,688,320.00	1,264,253,900.00
Үндсэн үйл ажиллагааны орлого	1,084,031,155.39	100,244,826.00
Туслах үйл ажиллагааны орлого	-	18,527,036.00
<b>2. Нийт зардал</b>	<b>1,289,068,059.66</b>	<b>1,442,857,424.44</b>
<b>Ажиллагчтай холбогдсон зардал</b>	<b>861,080,496.12</b>	<b>896,066,170.74</b>
Нийгмийн даатгал	87,920,668.91	94,545,553.19
Цалин	398,013,701.40	447,832,220.73
Цалингийн тусгай нэмэгдлүүд	375,146,125.81	353,688,396.82
<b>Бараа үйлчилгээний зардал</b>	<b>388,169,910.54</b>	<b>471,610,053.70</b>
<b>Нийтлэг чанартай зардал</b>	<b>269,487,043.59</b>	<b>424,867,030.07</b>
Гэрэл цахилгаан	-	1,853,312.00
Түлш, халаалтын зардал	-	12,305,800.00
Цэвэр , бохир усны зардал	-	6,185,700.00
Бичиг хэргийн зардал	8,738,560.00	4,356,920.00
Тээвэр шатахууны зардал	3,806,500.00	4,891,599.99
Шуудан холбооны зардал	1,784,475.69	1,308,694.63
Ном хэвлэлийн зардал	393,200.00	-
Эд хогшил худалдаг авах зардал	20,641,532.69	35,230,794.00
Нормын хувцас зөвлөн эдлэл	5,027,786.00	4,965,870.00
Урсгал засварын зардал	3,527,680.00	4,460,580.00
Эмийн зардал	133,397,370.00	141,863,238.00
Төлбөр , хураамж	72,059.63	76,700.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	2,194,540.00	5,252,000.00
Хог хаягдал, устгал	6,661,880.00	7,222,321.00
Байрны түрээсийн зардал	15,896,892.00	-
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	67,344,567.58	194,893,500.45
<b>Тусгай материал , үйлчилгээний зардал</b>	<b>117,791,466.95</b>	<b>44,295,803.63</b>
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	7,252,550.00	9,850,740.00
Салбарын төвлөрсөн арга хэмжээ	110,538,916.95	34,445,063.63

<b>Улсын маягт</b>	-	<b>583,220.00</b>
Улсын маягт	-	583,220.00
<b>Томилолтын зардал</b>	<b>891,400.00</b>	<b>1,864,000.00</b>
Дотоод томилолтын зардал	891,400.00	1,864,000.00
<b>Татаас санхүүжилт</b>	<b>39,730,653.00</b>	<b>75,181,200.00</b>
Тэтгэвэрт гараад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,057,000.00	75,181,200.00
Шагнал , урамшуулал	28,673,653.00	
<b>Бусад зардал</b>	<b>87,000.00</b>	-
Тээврийн хэрэгслийн даатгал	87,000.00	
<b><u>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</u></b>	<b><u>858,651,415.7</u></b>	<b><u>-59,831,662.4</u></b>

**Аудиторын дүгнэлтийн хавсралт 4**

**АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН СТ-4**

**"Эмгэг судлалын үндэсний төв"**

(Байгууллагын нэр)

2017 он

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	01 дүгээр сарын 01	12 дугаар сарын 31
<b>1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,248,356,244.96</b>	<b>1,378,714,200.00</b>
Улсын төсвөөс	1,063,688,320.00	1,264,253,900.00
Үндсэн үйл ажиллагааны орлого	-	15,793,000.00
Туслах үйл ажиллагааны орлого	184,667,924.96	98,667,300.00
<b>2. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>1,221,067,712.92</b>	<b>1,243,779,350.00</b>
<b>Ажиллагчтай холбогдсон зардал</b>	<b>859,512,216.96</b>	<b>895,718,644.74</b>
Нийгмийн даатгал	86,694,198.21	94,649,319.19
Цалин	772,818,018.75	801,069,325.55
Цалингийн тусгай нэмэгдлүүд	-	-
<b>Бараа үйлчилгээний зардал</b>	<b>321,867,742.96</b>	<b>272,879,505.26</b>
<b>Нийтлэг чанартай зардал</b>	<b>200,525,186.01</b>	<b>225,726,801.63</b>
Гэрэл цахилгаан	-	1,853,312.00
Түлш, халаалтын зардал	-	12,305,800.00
Цэвэр , бохир усны зардал	-	6,185,700.00
Бичиг хэргийн зардал	6,465,770.00	3,525,940.00
Тээвэр шатахууны зардал	3,971,500.00	4,427,600.00
Шуудан холбооны зардал	1,784,475.69	1,308,694.63
Ном хэвлэлийн зардал	393,200.00	-
Эд хогшил худалдаг авах зардал	21,661,788.69	30,042,055.00
Нормын хувцас зөөлөн эдлэл	3,750,260.00	4,991,200.00
Урсгал засварын зардал	4,632,980.00	9,156,400.00
Эмийн зардал	133,028,500.00	138,878,420.00
Төлбөр , хураамж	72,059.63	6,600.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	2,281,540.00	5,265,000.00
Хог хаягдал, устгал	6,586,220.00	7,780,080.00
Байрны түрээсийн зардал	15,896,892.00	-
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	-	-
<b>Тусгай материал , үйлчилгээний зардал</b>	<b>120,451,156.95</b>	<b>44,295,903.63</b>
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	9,912,240.00	9,850,840.00
Салбарын төвлөрсөн арга хэмжээ	110,538,916.95	34,445,063.63

<b>Улсын маягт</b>	-	<b>992,900.00</b>
Улсын маягт	-	992,900.00
<b>Томилолтын зардал</b>	<b>891,400.00</b>	<b>1,863,900.00</b>
Дотоод томилолтын зардал	891,400.00	1,863,900.00
<b>Татаас санхүүжилт</b>	<b>39,687,753.00</b>	<b>75,181,200.00</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,057,000.00	75,181,200.00
Шагнал , урамшуулал	28,630,753.00	
<b>Бусад зардал</b>	-	-
Тээврийн хэрэгслийн даатгал	-	
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>27,288,532.04</b>	<b>134,934,850.00</b>
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн</b>	-	
<b>Хөрөнгийн зардал</b>	<b>27,284,000.00</b>	<b>134,941,850.00</b>
Биет бус хөрөнгө худалдан авах зардал	27,284,000.00	134,941,850.00
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн</b>	<b>27,284,000.00</b>	<b>134,941,850.00</b>
<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(27,284,000.00)</b>	<b>(134,941,850.00)</b>
Мөнгөн гүйлгээний тэнцэл	4,532.04	(7,000.00)
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	4,532.04	(7,000.00)
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний улдэгдэл	5,000.00	9,532.04
<b><u>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн улдэгдэл</u></b>	<b><u>9,532.04</u></b>	<b><u>2,532.04</u></b>

## АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

СТЗ

**"Эмгэг судлалын үндэсний төв"**

(Байгууллагын нэр)

2017 он

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуриятлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2015.01.01 Эцсийн үлдэгдэл</b>	368,401,756.70	-	(232,696,507.82)	135,705,248.88
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны запруулга	-	-		-
Залруулсан үлдэгдэл	368,401,756.70	-	(232,696,507.82)	135,705,248.88
Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал	-	-	858,651,415.73	858,651,415.73
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-		-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-		-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
<b>2015.03.31 Эцсийн үлдэгдэл</b>	368,401,756.70	-	625,954,907.91	994,356,664.61
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны запруулга	-	-		-
Залруулсан үлдэгдэл	368,401,756.70	-	625,954,907.91	994,356,664.61
Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал	-	-	(59,831,662.44)	(59,831,662.44)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-		-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-		-
Зарласан ногдол ашиг	-	-		-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-		-
<b>2016.12.31 Эцсийн үлдэгдэл</b>	368,401,756.70	-	566,123,245.47	934,525,002.17

**ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АУДИТ ХИЙГДСЭН 2016 ОНЫ ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

	ҮЗҮҮЛЭЛТ	ТОДРУУЛГА	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ХУВЬ
1	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН</b>		<b>1,214,753,900.60</b>	<b>1,247,928,200.00</b>	100
2	<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>		<b>1,214,753,900.60</b>	<b>1,247,928,200.00</b>	100
3	<b>ҮРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>1,214,753,900.60</b>	<b>1,247,928,200.00</b>	100
4	<b>Бараа үйлчилгээний зардал</b>		<b>1,139,572,700.60</b>	<b>1,138,368,307.37</b>	91.22
5	<b>Цалин хөлсний нэмэгдэл урамшуулал</b>		<b>798,428,700.00</b>	<b>798,428,699.55</b>	63.98
6	Үндсэн цалин		614,212,200.00	609,243,240.55	48.82
7	Үр дүн урамшуулал		97,944,000.00	86,272,500.00	6.91
8	Унаа хоолны хөнгөлөлт		86,272,500.00	102,912,959.00	8.25
9	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>95,412,700.60</b>	<b>94,289,246.19</b>	7.56
10	Тэтгэврийн даатгал		55,890,009.00	55,890,009.00	4.48
11	Тэтгэмжийн даатгал		6,387,429.60	6,387,429.60	0.51
12	ҮОМШӨ-ний даатгал		15,968,574.00	15,968,574.00	1.28
13	Ажилгүйдлийн даатгал		1,596,857.40	1,596,857.40	0.13
14	Байгууллагын төлөх ЭМД-ийн хураамж		15,569,830.60	14,446,376.19	1.16
15	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>245,731,300.00</b>	<b>245,650,361.63</b>	19.68
16	Бичиг хэрэг		1,524,200.00	2,118,060.00	0.17
17	Гэрэл цахилгаан		1,933,500.00	1,853,312.00	0.15
18	Тулш халаалт		12,305,800.00	12,305,800.00	0.99
19	Цэвэр бохир ус		6,185,700.00	6,185,700.00	0.5
20	Тээвэр шатахуун		7,501,600.00	4,427,600.00	0.35
21	Шуудан холбоо		1,438,300.00	1,308,694.63	0.1
22	Дотоод томилолт		1,864,000.00	1,864,000.00	0.15
23	Төлбөр хураамж			7,000.00	0
24	Эд хогшил худалдан авах		45,906,500.00	48,516,195.00	3.89
25	Багаж, техник хэрэгсэл		26,374,900.00	26,374,900.00	2.11
26	БҮТЭЗ худалдан авах		19,531,600.00	22,141,295.00	1.77
27	Хичээл үйлдвэрлэлийн дадлага		-	0	
28	Нормын хувцас зөөлөн эдлэл		4,991,200.00	4,991,200.00	0.4
29	Эм		138,878,600.00	138,878,420.00	11.13
30	Ургал засвар		9,156,800.00	9,156,400.00	0.73
31	Хог хаягдал цэвэрлэх		7,780,100.00	7,780,080.00	0.62
32	Улсын маягт		1,000,000.00	992,900.00	0.08
33	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил</b>		<b>5,265,000.00</b>	<b>5,265,000.00</b>	0.42
34	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс		3,098,000.00	3,098,000.00	0.25
35	Аудитын баталгаажилт зардал		2,000,000.00	2,000,000.00	0.16
36	Тээврийн хэрэгслийн даатгал		70,000.00	70,000.00	0.01
37	Тээврийн хэрэгслийн оншилгоо		17,000.00	17,000.00	0
38	Тээврийн хэрэгслийн татвар		80,000.00	80,000.00	0.01
39	Өрх гэрт олгох шилжүүлэг		<b>75,181,200.00</b>	<b>75,181,200.00</b>	6.02
40	Тэтгэвэрт гарсан ажил олгох тэтгэмж		75,181,200.00	75,181,200.00	6.02
41	Үндсэн хөрөнгийн элэгдэл			0	
42	Төвлөрүүлэх шилжүүлэг			<b>34,378,692.63</b>	2.75
43	<b>ЗАРДАЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>1,214,753,900.00</b>	<b>1,247,921,200.00</b>	100
44	ЭМД-аас санхүүжих				
45	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		65,500,000.00	98,667,300.00	7.91
46	Бусад орлого /төсөл арга хэмжээ/		-		
47	Төсвээс санхүүжих		1,149,253,900.00	1,149,253,900.00	92.09
48	Оны эхний үлдэгдлээс санхүүжүүлэх				
49	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл				
50	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл			9,532.04	0
51	Үндсэн үйл ажиллагааны үр дүн			2,532.04	0
52	<b>Ажиллагсад бүгд</b>		68	57	100
53	Удирдах ажилтан		1	1	1.75
54	Гүйцэтгэх ажилтан		50	46	80.7
55	Үйлчлэх ажилтан		17	10	17.54